Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн Гүйцэтгэх захирлын
2022 оны 08 сарын 24-ны өдрийн
А/92 тоот тушаалын Хоёрдугаар хавсралт Маягт-9

MONGOLIA NETCOM
ӨНДӨР ХУРДНЫ ҮНДЭСНИЙ СҮЛЖЭЭ

БАТЛАВ
МЭДЭЭЛЭЛ ХОЛБООНЫ СҮЛЖЭЭ
ХХК-ИЙН БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ГАЗРЫН ДАРГА
.....Ш.АРДАХ

ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

Дугаар А-А2025/06

2025 оны 03 сарын 12 өдөр

Баян-Өлгий аймаг

Захиалагч байгууллага: БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Хэрэглэгчийн нэр: Е. Зангар

Харилцах утас: 70422483

Байршил: Баян-Өлгий аймаг Өлгий сум 8-р баг 900,1000 айлын орон сууц

Сувагчлалаар татах шилэн кабелийн хэрэгцээ:

д/д	Кабель шугамын тасаг	Чиглэлийн нэр:	Сувагчлалын урт (м)	Худгийн тоо (ш)	Агаараар (м)
1	Баян-Өлгий аймгийн МХС ХХК-ийн КШ-ын тасаг.	Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн төв байрны 2-р давхрын техникийн өрөөнөөс оруулгын худаг хүртэл 30м шилэн кабель оруулгын худгаас Алкателийн 15-р худаг хүртэл одоо ашиглаж байгаа сувагчлалаар 1298 м шилэн кабель сүвлэнэ. Алкателийн 15-р худгаас шинээр баригдах Хутты мекен хороолол болон 900,1000 айлын орон сууцны хороолол хүртэл 1156 метр газарт шинээр Ф100 пластмассан яндангаар 2эгнээ сувагчлал хийж 7ш L5 худаг шинээр суурилуулан. Шинээр суурилуулсан худаг сувагчлалаар шилэн кабелийг 1289м сүвлэн тус хороололуудын Холбооны техникийн өрөөнүүдэд оруулан FDF-д холбож өгнө.	2454	22	

1. ***Техникийн онцгой нөхцөл:*** Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгогдсон харилцаа холбооны үндсэн сүлжээ байгуулах эрхийнхээ дагуу техникийн нөхцлийг зөвхөн Мэдээлэл холбооны сүлжээ ХХК олгоно. Техникийн нөхцөлгүйгээр холбооны худаг сувагчлал байгуулах, кабель татах,

шилжүүлэх тохиолдолд уг барилга обьектыг техникийн комисс болон улсын комиссоор хүлээн авахгүй болно.

2. Техникийн үндсэн нөхцөл:

2.1 Угсралт суурилуулалтын ажлыг Харилцаа Холбооны Зохицуулах Хорооноос олгосон холбооны кабель шугамын угсралт хийх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэнэ.

2.2 Худаг сувагчлалаар шинээр шилэн кабель суурилуулахдаа Монгол Улсын MNS 5207:2011, MNS 5278:2012, MNS 5317:2011 стандартуудыг мөрдөнө.

2.3 Угсралтын ажил эхлэхийн өмнө тус газрын харъяалагдах нэгжид мэдэгдэн ажил эхлэх зөвшөөрөл авна.

2.4 Техникийн нөхцлийн дагуу гүйцэтгэсэн ажлыг техникийн актаар хүлээлгэн өгөөгүй тохиолдолд түүнд гарах аливаа эрсдэл, гэмтэл саатлын хариуцлагыг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК хариуцахгүй болно.

2.5 Техникийн нөхцлийн дагуу худаг сувагчлалын түрээсийн гэрээ байгуулна.

3. Угсралтын ажлын үед тавигдах шаардлага:

3.1 Угсралтын ажлын явцад захиалагч ашиглалтын байгууллагатай хамтран хяналт тавьж, угсралтын технологийн шаардлагыг бүрэн хангуулсан байх.

3.2 Шилэн кабелийг худагт нөөц үлдээхгүй татах бөгөөд зөвхөн төгсгөлийн төхөөрөмж байрлуулах хэсэгт нөөц авахыг зөвшөөрнө.

3.3 Шинээр татсан кабельд биркийг /хаягжилт/ худаг бүрт болон төгсгөлийн төхөөрөмжид бүрэн хийсэн байх ба худагт кабелийн залгаа хийх тохиолдолд муфтыг худгийн хананд тусгай тавиур хийж байрлуулсан байх.

3.4 Кабелийг техникийн нөхцөлд заасан трассын дагуу татаагүй тохиолдолд ашиглалтын явцад гарах эрсдэлийг Мэдээлэл холбооны сүлжээ ХХК хариуцахгүй болно.

4. Угсралтын ажил дууссаны дараа тухайн ажлыг AutoCAD-ын гүйцэтгэлийн зураг хийлгэж, тухайн ашиглалт хариуцсан газарт техникийн актаар хүлээлгэн өгнө.

5. Техникийн нөхцлийг Аймгийн Засаг Даргын 2025 оны 01 сарын 27-ний өдрийн 1-01/82 тоот албан бичиг, хүсэлтийг үндэслэн олгов.

6. Энэхүү техникийн нөхцөл нь батлагдсан өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй байна. Техникийн нөхцлийн хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгалт хийлгэх хүсэлт хүлээн авч, сунгах боломжтой.

Хянасан: ..... К.ЕСИМ
/ Ерөнхий инженер /

Боловсруулсан: ..... М.ЖЕНИС
/ КШ-ын инженер /

ӨЛГИЙ СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАРИГДАХ 900,1000 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ БОЛОН "ХУТТЫ МЕКЕН" ХОРООЛОЛ ХҮРТЭЛ ТАТАГДАХ ШИЛЭН КАБЕЛИЙН ЗУРАГ



ХЯНАСАН:

ЗУРСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР: К. ЕСИМ

КАБЕЛЬ ШУГАМЫН ИНЖЕНЕР: М. ЖЕНИС

ӨЛГИЙ СУМЫН 8-Р БАГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ БАРИГДАХ 900,1000 АЙЛЫН ОРОН СУУЦНЫ ХОРООЛОЛ БОЛОН "ХУТТЫ МЕКЕН" ХОРООЛОЛ ХҮРТЭЛ ТАТАГДАХ ШИЛЭН КАБЕЛИЙН ЗУРАГ



ХЯНАСАН:

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР: К. ЕСИМ

ЗУРСАН:

КАБЕЛЬ ШУГАМЫН ИНЖЕНЕР: М. ЖЕНИС